

МИСС ТЭМДЭГЛЭЛ

MISS.mn

2012 ОНЫ 1 ДҮГЭЭР САРЫН 5 (3)

14 хоног тутам гарна

MONGOLIA INTERNATIONAL CAPITAL CORPORATION — Монголын тэргүүлэх хөрөнгө оруулалтын банк

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОВЧ МЭДЭЭ

- **Монголын Хөрөнгийн Бирж** 2011 онд өсөлтөөрөө дэлхийд хоёрт оров. Нэгд Венесуэлийн бирж 81 хувийн өсөлттэйгөөр орлоо.
- **Монгол Банкны** долларын албан ханш 1,412.25 хүрлээ.
- **МАК** компанийн 105 сая долларын зэс баяжуулах үйлдвэрийг Дорноговь аймгийн Мандах суманд FLSmidth барина.
- **Монголиа Грөүт Групп** (үл хөдлөх хөрөнгө, даатгал) 15 сая канад долларын хаалттай нэмэлт хувьцаа гаргалаа.
- **Витафит** 6.5 сая долларын зээлийг Европын Сэргэн Босголын Банкаас авна.
- **Хаан Ресурсес** (уран) хуучны хамтрагч Атомредметзолото-г шүүхэд өгчээ. Хаан Ресурсес Монголын Засгийн газрыг мөн шүүхэд өгсөн билээ.
- **Монвест**-ийн хувьцааг Ренел Франкфуртын бирж дээр гаргах болжээ. Монвест нь Малайз эзэнтэй, Монголд хонжворт сугалаа гаргадаг компани юм.
- **Блү Волф**-ын хувьцааг NASDAQ дээр арилжсан тоо хэмжээ 95.2 хувиар буурчээ.

ГАРЧИГ

- **ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ.** (Нүүр 2)
- **ТАНЫ МЭДЛЭГТ.** Түүхий эдийн үнэ (нэгдүгээр хэсэг) (Нүүр 3)
- **ЭДИЙН ЗАСАГ ЗУРГААР.** 2011 оны их савлагаа (Нүүр 4)

МИСС Цаст Пропертис-д 10 сая Еврогийн санхүүжилт олж өглөө



ЦАСТ Пропертис-д МИСС 10 сая еврогийн зээлийн санхүүжилтийг амжилттай олж өглөө. Энэхүү зээлийг ашиглан Цаст Пропертис "Олон Улсын Худалдааны Төв" буюу *International Commerce Center* хэмээх 21 давхар оффисийн барилгыг барьж, 2012 оны эцэст ашиглалтанд оруулах юм. Хотын Захиргааны анхны хоёр давхар байшингийн буурин дээр баригдаж буй энэ барилга нь Гадаад Хэргийн Яамнаас Драмын театр руу

чиглэсэн Жамъяан Гүний гудамжны зүүн урд талд байрладаг. Барилгын зураг төслийг БНХАУ-ын томоохон зураг төслийн компанитай Монголын архитекторууд хамтран Монгол орны онцлогт тохируулан боловсруулжээ. ■

"Алтан Хувьцаа" анхны шагналаа олгов

Бидний С1 телевизтэй хамтран зохион байгуулж буй хувьцаа арилжих тэмцээний эхний долоо хоногийн ялагч тодорч, хамгийн өндөр өсөлттэй багцыг бүрдүүлсэн Анагаах Ухааны Их Сургуулийн 6-р курсын оюутан Г. Ням-Од зуун мянган төгрөгийн шагналыг авлаа. Бүх оролцогчид 10 сая төгрөгийн хийсвэр мөнгөтэй эхэлсэн бөгөөд Ням-Одын багцийн нийт дүн 9 хоногийн дотор (12-р сарын 23 гэхэд) 15 саяаас илүүтэй болсон байв.

Бидний бодлоор 6 долоо хоногт мөнгө өсгөх, урт удаан хугацаагаар хөрөнгөө өсгөх хоёрын хооронд маш том ялгаа байгаа бөгөөд, энэ хоёр зорилгод хоёр өөр хөрөнгө оруулалтын арга барил таарч байна. Тэмцээнд хийсвэр мөнгөөр арилжаа явагддаг болохоор алдах юмгүй, хамгийн их эрсдэлтэй багцыг сонгосон оролцогчид ялах магадлал өндөртэй. Бодит амьдрал дээр хөрөнгө оруулалт хийхэд мэдээж алдах юмгүй байна гэж байдаггүй учраас тэс ондоо арга барил, эрсдлийн хамгаалалт шаардагдана.

Даваа гаргийн 21 цаг 10 минутаас С1 телевиз дээр гардаг энэхүү нэвтрүүлэгт манай брокер, шинжээчид өөрсдийн дүгнэлт, шинжилгээнээс хуваалцах болно. ■

МИСС ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНК

Сентрал Тауэр 912, Сүхбаатарын Талбай 2


Утас: 70112024



MISS

Mongolia's Investment Bank

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ



Дэлхийн томоохон орнууд 8 их наяд гаруй ам.долларын өрийг 2012 онд барагдуулах ёстой

ИХ БРИТАНИ, Америк, Франц, Герман, Итали, Япон, Канад буюу "Г-7" орнуудын дээр Орос, Энэтхэг, Хятад, Бразилийн 2012 онд төлж барагдуулах ёстой нийт өрийг нэмвэл 8 гаруй их наяд ам.доллар гэсэн тоо гарч байна. Эдгээр орнууд өнгөрсөн жил ойролцоогоор 7.4 их наяд ам.долларын өр зээлийг барагдуулжээ. Гэвч энэ жил дэлхийн эдийн засаг удааширч байгаатай холбогдуулан хөрөнгө оруулагчдын шаардах урт хугацааны зээлийн хүү өсөх хандлагатай байна.

Өрийн жагсаалтыг Япон 3 их наяд ам.доллар төлөх ёстойгоороо тэргүүлж байгаа бол Америк 2.8 их наядыг төлөх ёстойгоороо удаалж байна. (Эх сурвалж: Bloomberg.)

Еврогийн бүсийн хямралын голд нь байгаа Италийн хувьд 500 тэрбум орчим ам.долларын өрийг 2012 онд барагдуулах ёстой ажээ. Энэ их мөнгө Италид бэлэн байхгүй учраас Итали нэмж бонд гаргах хэрэгтэй болно. Бондын хүү шинжээчид хамгийн их анхаарал тавина. 12 дугаар сарын 29-нд Итали нийт 8.5 тэрбум Еврогийн

бонд зарах төлөвлөгөөтэй байснаас ойролцоогоор 7 тэрбумыг зарж чадсан. Гурван жилийн бондных нь хүү унасан боловч 10 жилийн бондных нь хүү 6.98 хувьтай байлаа. Энэ хүү буурахгүй бол Италид өрөө төлөхөд улам л хэцүү болно. ■

12 дугаар сард Хятадын байрны үнэ унаж, PMI 48.7 гарлаа

БИД өмнөх дугаартаа Хятадын үйлдвэрлэлийн салбарын төлөв байдлыг хэмждэг PMI хэмжүүрийн тухай мэдээллэж байсан билээ. Энэ хэмжүүр 12 дугаар сард эцсийн байдлаар 48.7 буюу бидний мэдээлсэн урьдчилсан гүйцэтгэлээс (49) ялимгүй бага гарсан байна. Энэ бол HSBC/Markit-ийн тооцоолсон PMI бөгөөд 11 дүгээр сард 47.7 байсан. Засгийн газрын албан ёсны хэмжүүрээр бол PMI 12 дугаар сард 50.3 гарчээ. Гэхдээ аль ч хэмжүүрийг авсан 50 буюу 50-с доош гэдэг бол бага үзүүлэлт. 12 дугаар сард үйлдвэрлэлийн салбар бага зэрэг өссөн байх шалтгаан нь баяр ёслолтой холбоотой. Шинэ жилийн баяраас гадна Хятадын цагаан сар 1 дүгээр сард болно.

Мөн 12 дугаар сард Хятадын байрны үнэ 0.25 хувиар унаж, үл хөдлөх хөрөнгийн үнийн уналт гуравдах сардаа үргэлжилж байна. ■

ТАНЫ МЭДЛЭГТ

Түүхий эдийн үнэ (нэгдүгээр хэсэг)

Б. Ачболд

ТҮҮХИЙ ЭДИЙН үнийн төлөв байдал үргэлж бидний анхааралд байх ёстой. Учир нь зэс, нүүрсний үнэ хөдлөхөөр Монголын эдийн засаг хөдөлдөг. Энэ бол уул уурхайн салбараас хэт хамааралтай байхын нэг сул тал юм. 2011 оны эхний 11 сард манай улс 4.3 тэрбум ам.долларын бараа бүтээгдэхүүнийг экспортолж гаргасан нь 2010 оны 2.9 тэрбумаас хол давсан билээ. Экспортын дийлэнх хэсгийг алт, зэс, нүүрс мэтийн анхдагч түүхий эд бүрдүүлдгийг бид мэднэ.

Нэг. Энэ олон үнийн аль нь чухал вэ?


Нүүрс дээр авч үзье л дээ. Нүүрсний үнүүд хоорондоо адилгүй байх олон шалтгаан байна: (1) Хүрэн нүүрсийг байшин халаах, эрчим хүч гаргахад ашигладаг бол коксжих нүүрсийг ган хийхэд ашиглана. Дээр нь коксжих нүүрс гэхэд л сайнаасаа муу чанартай хүртлээ байдаг. Тиймээс нүүрс болгон адилхан үнээр зарагдахгүй. (2) Нүүрсний эрэлт хэрэгцээ, нийлүүлэлт газар болгон адилгүй байдаг. Үүнээс болж яг адилхан нүүрс газар газар ялгаатай үнээр зарагдана. (3) Дөнгөж олборлосон нүүрсийг уурхай дээр нь худалдаж авбал нүүрсээ зөөвөрлөх тээврийн зардлыг тооцно. (4) Боловсруулсан нүүрс илүү үнэд хүрнэ.

Жишээ нь "Энержи Ресурс", "Саус Гоби" хоёулаа коксжих нүүрс зардаг боловч Энержи Ресурсын нүүрс илүү чанартай байдаг. Энержи Ресурсын боловсруулсан нүүрс хил дээр 150 орчим ам.долларт хүрч байхад Саус Гоби-гийнх 80-90 орчим долларт хүрдэг.

Гэхдээ нүүрсний олон үнэ ерөнхийдөө зах зээлийн хуулиар хамтдаа өсч, унаж байдаг. Ганц нүүрс гэлтгүй, ер нь дэлхийн томоохон түүхий эдийн зах зээлүүд дээрх үнэ хөдлөхөд бидний түүхий эдээ зарах үнэ тодорхой хугацааны дараа дагаад хөдөлнө. Тиймээс олон үнийн нэгийг нь стандарт болгож болдог. Жишээ нь зарим эдийн засагчид Австралийн Японд зардаг коксжих нүүрсний үнийг стандарт болгож авдаг. Энэ нь мэдээж тодорхой тогтсон үзүүлэлт, чанар бүхий нүүрс байна.

Хоёр. Түүхий эдийн үнэ сүүлийн 20 жилд яаж өөрчлөгдсөнийг харъя.

Алт зэсийн үнэ, сүүлийн 20 жилд



Австралийн чулуун нүүрсний үнэ (ам.доллар/тонн)




Дээрх зургуудаас хоёр зүйл ажиглагдана:

Нэгд, сүүлийн 6-7 жилд алт, зэс, нүүрсний үнэ их өссөн байна. Өсөхдөө 20, 30 хувиар биш, бүр 200, 300 хувиар өссөн. Бусад түүхийн эдийн үнийг харвал мөн л иймэрхүү байдлаар өссөн байдаг.

Хоёрт, 2008 онд санхүү эдийн засгийн хямрал болж дэлхийн эдийн засаг удаашрахад алтыг эс тооцвол бусад түүхий эдийн үнэ огцом унасан. Ер нь эдийн засаг уналттай үед ирээдүйн эрэлт хэрэгцээ багасна гэсэн тооцоон дээр түүхий эдийн үнэ унадаг. (Харин зарим хөрөнгө оруулагчид ийм уналттай үед бонд, хувьцаагаа зарж оронд нь алт худалдаж авдаг тал бий.)

Тиймээс түүхий эд дэлхийн зах зээл дээр харьцангуй өндөр үнэтэй байгаа бөгөөд энэ нь Монголын эдийн засгийн өсөлт өндөр байсны нэг гол шалтгаан юм. Мөн уул уурхайн компаниуд Монголд сүүлийн жилүүдэд олширсон шалтгааныг үүгээр тайлбарлаж болно.


Түүхий эдийн үнэ яагаад ингэж их өссөн бэ? Үүнд эдийн засагчид хоорондоо зөрчилдөх хоёр хариултыг өгдөг. Эхнийх нь бол мэдээж эрэлт, нийлүүлэлтийн тухай уламжлалт хариулт. Сүүлийн жилүүдэд Хятадын түүхий эдийн эрэлт огцом өссөнийг доорх зургаас харж болно (BNP Paribas, 2011* урьдчилсан гүйцэтгэл).



Хоёрдох тайлбараар бол хөрөнгө оруулагчид сүүлийн жилүүдэд хөрөнгийн багцаа төрөлжүүлэхийг зорин түүхий эдийн *фьючерсийн* зах зээлрүү их хэмжээний мөнгө оруулсан бөгөөд, үүгээрээ түүхий эдийн үнийг хөөрөгдөлд оруулсан гэдэг. (Фьючерсийн зах зээл дээр түүхий эдийг ирээдүйд тодорхой үнээр худалдана гэсэн гэрээг байгуулдаг.) Энэ тайлбар үнэн байж болох авч тоо баримтаар батлахад хэцүү юм.

Энэхүү өгүүлэлтийн хоёрдугаар хэсэг түүхий эдийн үнэ яагаад дээшээ доошоо савладаг болон, түүхий эдийн үнийн ирээдүйн төлөв байдлын талаар үргэлжилнэ. ■

ЭДИЙН ЗАСАГ ЗУРГААР



Дэлхийн зах зээлүүдийн хувьд 2011 он их савлагаатай жил байлаа. S&P 500 индекс жишээ нь 2011 онд 50 жилд савлаж байгаагүйгээрээ савласан гэж Bloomberg мэдээллэсэн.

Дэлхийн зах зээлүүд тогтворгүй байсны гол шалтгаан бол тодорхой: ихэнх хөрөнгө оруулагчдын хувьд зах зээл хаашаа хөдлөх гээд байгаа нь 2011 оны турш ойлгомжгүй байсан. 2009 оны уналтаас аажмаар гарч ирэх ёстой байсан Америкийн эдийн засаг өсөхгүй, бүр удаахрах хандлагатай байсны дээр Еврогийн бүсээс өдөр ирэх тутам улам муу мэдээлэл гарч байлаа.


Мөн 2011 онд тааж мэдэхэд хэцүү олон үйл явдал болсон: Японы цунами, Араб даяар болсон "Арабын Хавар" хувьсгалууд, Америкийн Засгийн газар өрөө төлөхгүй байж магадгүй нь гэсэн сандрал, S&P Америкт өгдөг AAA үнэлгээгээ бууруулсан явдал, Европын удирдагчид Еврогийн бүсийн өрийн хямралыг зогсоож чадахгүй асуудлыг улам хүндрүүлсэн явдал. Манай Монголын хувьд Таван Толгойн Баруун Цанхид ажиллах гэрээлэгч компаниудын нэрсийг эцсийн байдлаар сонгоогүй байхад зарласан. Мөн Оюу Толгойн гэрээг өөрчилнө гэсэн мэдээлэл гаргаснаа удалгүй шийдвэрээсээ буцлаа гэсэн мэдэгдлийг Айванхоу Майнз, Рио Тинто, Монголын Засгийн газар хамтаран гаргасан. Энэ бүхэн зах зээлд эрс тэс уур амьсгалыг авчирч 2011 оныг хөрөнгө оруулагчдын хувьд түгшүүртэй, нойр багатай жил болголоо.


Эцсийн дүнд дэлхийн томоохон хөрөнгийн биржүүд 2011 оныг уналттайгаар үдлээ. Уналт оны хоёрдугаар



хагасаас эхэлсэн бөгөөд одоо болтол хаашаа эргэх нь тодорхойгүй байна. Энэ байдал Монголд үйл ажиллагаа явуулж буй гадаадын компаниудад хамгийн их нөлөөлж, МИСС-ийн тооцоолж гаргадаг Монголын Уул Уурхайн Индекс 2011 онд 31.2 хувиар унасан. Индексийн томоохон хэсгийг бүрдүүлдэг Айвенхоу Майнз 2011 онд 22.7 хувиар, Монголиан Майнинг Корпораци (Энержи Ресурс) 35.3 хувиар унажээ. Бид энэхүү уналтын үндсэн шалтгаан болоод байгаа Еврогийн бүсийн хямралын тухай өмнөх дугаартаа мэдээллэж байсан.

Монголын Хөрөнгийн Бирж (МХБ)-ийн хувьд 2011 оны хоёрдугаар хагаст өсөөгүй ч жилдээ 39 хувиар өссөн байна. Сонирхолтой нь оны эхэнд, гурван сар хүрэхгүй хугацаанд Топ 20 Индекс 123 хувиар өссөн байсан. Гэвч энэ хөөрөгдлөө дараагийн сард нь маш хурдан засч, нэг бодлын хий хөөрөгдөлд орохоосоо сэргийлсэн. Бид 2012 онд МХБ-д гарах өөрчлөлтүүдийн үр дүнг анхааралтай харж байх болно. ■





MICC

Mongolia's Investment Bank

THIS IS THE MICC JOURNAL, A BI-MONTHLY FINANCE AND ECONOMICS PAPER PUBLISHED BY MICC, THE LEADING INVESTMENT BANK IN MONGOLIA.

МIСС ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНКНЫ ТУХАЙ
МIСС нь компанийн санхүүжилт, үнэт цаасны арилжаа, судалгаа, хөрөнгийн удирдлага зэрэг цогц үйлчилгээг дотоод гадаадын харилцагчиддаа санал болгодог Монголын ууган хөрөнгө оруулалтын банк юм.

МIСС ТЭМДЭГЛЭЛ-ийн тухай
Хоёр долоо хоног болгон гарах энэ бяцхан сонин танд эдийн засаг, санхүүгийн мэдээлэл өгөх боловч хөрөнгө оруулалтын зөвлөгөө өгөхгүй.

Таны эрсдэл таны хариуцлага.

Эрхлэгч: Б. Ачболд.

2012/1/5

Мэдээллийн Эх Сурвалжууд

Топ 20 Индексийн мэдээллийг МХБ-ээс, түүхий эдийн үнийн тоо баримтийг Олон Улсын Вальютын Сангаас, долларын албан ханшийн мэдээллийг Монгол Банкаас, хувьцааны мэдээллийг Bloomberg-с авлаа.